



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2009 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 581

Улаанбаатар хот

Г Сургалтын төрийн сангийн
зээлээр гадаадад сургах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 тоот тогтоолоор баталсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар баталсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сүрэнхорлоо овогтой Содгэрэлийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Америкийн Нэгдсэн Улсын Arington кампусын Strayer University-ийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар, Отгонбат овогтой Орхон²ыг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын захиалгаар Америкийн Нэгдсэн Улсын Northeastern Illinois их сургуулийн магистрантурт нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар, Шархүү овогтой Эрдэнэбаяр³ыг Монгол банкны захиалгаар Австрали улсын Технологийн Swinburne-ийн их сургуулийн магистрантурт худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр 1,5 жилийн хугацаатайгаар, Содхүү овогтой Гэрэлмаа⁴г төрийн өмчийн хорооны захиалгаар Америкийн Нэгдсэн Улсын Strayer University-ийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 1 жилийн хугацаатайгаар, Мэдраа овогтой Мөнхөөг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Америкийн Нэгдсэн Улсын University of Bridgeport-ийн урлагийн магистрантурт глобал энх тайван ба хөгжлийн удирдлага чиглэлээр 0,5 жилийн хугацаатайгаар, Цагаан овогтой Мөнхтүвшинг Сангийн яамны захиалгаар Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хот дахь Америкийн их сургуульд бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар тус тус суралцуулсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасгай.



Ё.ОТГОНБАЯР